

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/147/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Дэвжих Капитал аудит ХХК-ийн захирал : Л.Отгон
Утас: 99059489 Цахим хаяг: devjikhcapital.audit@gmail.com
Аудитор: Ц.Базарсад
Утас: 99065336 Цахим хаяг: bazka0330@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 7048-4030,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.02.24 № 71

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллагын улсын төсвийн санхүүжилт өмнөх оноос 42,431.7 мянган төгрөгөөр өссөн, орон нутгийн төсвийн санхүүжилт 336,903.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,800.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 19,240.5 мянган төгрөгийн элэгдлээрээ өртөгөө нөхсөн хөрөнгийг данснаас хасч, дахин 9,440.0 мянган төгрөгөөр үнэлэн бүртгэсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 56 дугаар тогтоолын дагуу 8,440.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 2025 оны 57 дугаар тогтоолоор 21,908.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг сумын Засаг даргын Тамгын газарт балансаас баланст шилжүүлсэн байна.

БАЯН-УУЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Е.ЛХАМСҮРЭН ТАНАА

822505000202

Бусад асуудал

Тайлант онд 1 хөтөлбөр, 8 зорилт, 72 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 69 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 3 арга хэмжээг 90.0 хэрэгжүүлж, нийт биелэлтийг 90.0 хувиар үнэлэн хүргүүлсэн бөгөөд аймгийн Боловсролын газраас 94.0 хувиар "Хангалттай гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б. ГҮНЖИДМАА

Хоёр .АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	169,538,921.37	83,249,605.25
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	118,132,633.17	32,583,522.05
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	118,132,633.17	32,583,522.05
3121	Төгрөг	118,132,633.17	32,583,522.05
31211	Төрийн сангийн харилцах	118,132,633.17	32,583,522.05
35	БАРАА МАТЕРИАЛ	51,406,288.20	50,666,083.20
351	Түүхий эд материал	1,000,000.00	1,225,000.00
35110	Тусгай зориулалттай материал	1,000,000.00	1,225,000.00
354	Хангамжийн материал	50,406,288.20	49,441,083.20
35410	Бичиг хэргийн материал	3,002,860.00	2,038,150.00
35420	Аж ахуйн материал	28,360,965.00	27,819,870.00
35450	Барилгын засварын материал	1,362,300.00	1,602,300.00
35460	Хүнсний материал	3,139,100.00	3,439,700.00
35470	Бусад хангамжийн материал	14,541,063.20	14,541,063.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	806,390,469.12	780,863,494.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	806,390,469.12	780,863,494.50
392	Биет хөрөнгө	800,170,469.12	774,643,494.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	772,266,884.09	772,266,884.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	(64,074,956.34)	(85,921,194.06)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	43,259,238.00	31,928,925.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(23,412,429.31)	(9,916,891.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	84,535,100.00	80,144,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,878,758.86)	(14,273,270.20)
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,511,679.65	603,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(22,099,288.11)	(251,458.50)
39217	Ном	63,000.00	63,000.00
393	Биет бус хөрөнгө	6,220,000.00	6,220,000.00
39301	Програм хангамж	720,000.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(720,000.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	6,220,000.00	6,220,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	975,929,390.49	864,113,099.75
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	13,832,442.30
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	13,832,442.30
413	Өглөг	-	13,832,442.30
4136	Бусад өглөг	-	13,832,442.30
41361	Байгууллагад төлөх өглөг	-	13,832,442.30
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	975,929,390.49	850,280,657.45
51	Засгийн газрын хувь оролцоо	975,929,390.49	850,280,657.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	296,402,953.84	296,402,953.84
51101	Өмч: - төрийн	296,402,953.84	296,402,953.84
512	Хуримтлагдсан үр дүн	507,498,319.56	399,976,587.00
51210	Өмнөх үеийн үр дүн	31,521,800.57	525,625,320.04
51220	Тайлант үеийн үр дүн	475,976,518.99	(125,648,733.04)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	172,028,117.09	153,901,116.61
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	975,929,390.49	864,113,099.75

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,105,551,860.00	730,232,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	91,544,700.00	10,597,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	91,544,700.00	10,597,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,000.00	157,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	157,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	90,439,700.00	9,440,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,000,000.00	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,014,007,160.00	719,635,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	603,409,600.00	645,941,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	603,409,600.00	645,941,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	410,597,560.00	73,693,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	410,597,560.00	73,693,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	628,969,179.33	855,880,733.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	628,969,179.33	855,880,733.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	628,826,348.88	853,563,405.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	438,507,180.78	575,516,657.12
210101	Үндсэн цалин	293,072,085.52	338,975,623.53
210102	Нэмэгдэл	123,937,645.26	192,220,753.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	17,995,000.00
210104	Урамшуулал	21,497,450.00	26,325,280.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,618,913.00	67,837,100.00
210201	Тэтгэврийн даатгал	36,823,411.00	46,133,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,085,088.00	5,427,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,052,855.00	2,714,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,883,435.00	2,714,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,774,124.00	10,846,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,366,598.55	64,219,813.25
210301	Гэрэл, цахилгаан	2,936,078.55	4,434,930.95
210302	Түлш, халаалт	37,271,520.00	59,705,082.30
210303	Цэвэр, бохир ус	159,000.00	79,800.00
2105	Нормативт зардал	56,749,850.00	65,474,580.00
210502	Хоол, хүнс	56,749,850.00	65,474,580.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,599,814.00	19,689,002.00
210604	Урсгал засвар	1,599,814.00	19,689,002.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	775,000.00	2,765,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	775,000.00	2,765,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,208,992.55	58,060,853.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,370,166.00	16,508,849.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	4,785,030.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,338,826.55	36,766,974.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	142,830.45	2,317,327.05
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	142,830.45	2,317,327.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	142,830.45	2,317,327.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	476,582,680.67	(125,648,733.04)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	606,161.68	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	606,161.68	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(606,161.68)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	475,976,518.99	(125,648,733.04)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,014,112,160.00</u>	<u>719,792,000.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	105,000.00	157,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	105,000.00	157,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,000.00	157,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	157,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,014,007,160.00	719,635,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	603,409,600.00	645,941,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	603,409,600.00	645,941,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	410,597,560.00	73,693,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	410,597,560.00	73,693,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>986,955,883.78</u>	<u>805,341,111.12</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	986,955,883.78	805,341,111.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	986,813,053.33	803,023,784.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	438,507,180.78	575,516,657.12
210101	Үндсэн цалин	293,072,085.52	338,975,623.53
210102	Нэмэгдэл	123,937,645.26	192,220,753.59
210104	Урамшуулал	21,497,450.00	26,325,280.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,618,913.00	67,837,100.00
210201	Тэтгэврийн даатгал	36,823,411.00	46,133,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,085,088.00	5,427,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,052,855.00	2,714,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,883,435.00	2,714,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,774,124.00	10,846,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,366,598.55	50,387,370.95
210301	Гэрэл, цахилгаан	2,936,078.55	4,434,930.95
210302	Түлш, халаалт	37,271,520.00	45,872,640.00
210303	Цэвэр, бохир ус	159,000.00	79,800.00
2105	Нормативт зардал	58,979,900.00	65,775,200.00
210502	Хоол, хүнс	58,979,900.00	65,775,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	370,088,131.00	20,989,002.00
210604	Урсгал засвар	370,088,131.00	20,989,002.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	775,000.00	2,765,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	775,000.00	2,765,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,477,330.00	19,753,054.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,273,500.00	14,710,984.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,203,830.00	5,042,070.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	142,830.45	2,317,327.05
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	142,830.45	2,317,327.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	142,830.45	2,317,327.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>27,156,276.22</u>	<u>(85,549,111.12)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	27,156,276.22	(85,549,111.12)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	90,976,356.95	118,132,633.17

Говь-Алтай аймгийн Баян -Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	118,132,633.17	32,583,522.05
----	---	----------------	---------------

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	296,402,953.84	172,028,117.09	31,521,800.57	499,952,871.50
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	296,402,953.84	172,028,117.09	31,521,800.57	499,952,871.50
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	475,976,518.99	475,976,518.99
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,402,953.84	172,028,117.09	507,498,319.56	975,929,390.49
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	296,402,953.84	172,028,117.09	507,498,319.56	975,929,390.49
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	18,127,000.48	18,127,000.48
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	296,402,953.84	172,028,117.09	525,625,320.04	994,056,390.97
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(18,127,000.48)	-	(18,127,000.48)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(125,648,733.04)	(125,648,733.04)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,402,953.84	153,901,116.61	399,976,587.00	850,280,657.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт Хэмнэлт	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	823,310,700.00	803,023,784.07	20,286,915.93	97.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	823,310,700.00	803,023,784.07	20,286,915.93	97.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	823,310,700.00	803,023,784.07	20,286,915.93	97.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	581,819,300.00	575,516,657.12	6,302,642.88	98.92
210101	Үндсэн цалин	381,499,500.00	338,975,623.53	22,523,876.47	93.77
210102	Нэмэгдэл	202,923,700.00	192,220,753.59	10,702,946.41	94.73
210104	Урамшуулал	17,396,100.00	26,325,280.00	(8,929,180.00)	151.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,373,100.00	67,837,100.00	4,536,000.00	93.73
210201	Тэтгэврийн даатгал	49,100,400.00	46,133,300.00	2,967,100.00	93.96
210202	Тэтгэмжийн даатгал	5,818,200.00	5,427,800.00	390,400.00	93.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,909,100.00	2,714,800.00	194,300.00	93.32
210204	Ажилгүйдлийн даатгал	2,909,100.00	2,714,800.00	194,300.00	93.32

Говь-Алтай аймгийн Баян -Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	11,636,300.00	10,846,400.00	789,900.00	93.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,693,700.00	50,387,370.95	2,306,329.05	95.62
210301	Гэрэл, цахилгаан	4,293,700.00	4,434,930.95	(141,230.95)	103.29
210302	Түлш, халаалт	48,000,000.00	45,872,640.00	2,127,360.00	95.57
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	79,800.00	320,200.00	19.95
2105	Нормативт зардал	71,447,500.00	65,775,200.00	5,672,300.00	92.06
210502	Хоол, хүнс	71,447,500.00	65,775,200.00	5,672,300.00	92.06
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,000,000.00	20,989,002.00	10,998.00	99.95
210604	Урсгал засвар	21,000,000.00	20,989,002.00	10,998.00	99.95
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,014,500.00	2,765,400.00	249,100.00	91.74
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,014,500.00	2,765,400.00	249,100.00	91.74
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,962,600.00	19,753,054.00	1,209,546.00	94.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,804,700.00	14,710,984.00	1,093,716.00	93.08
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,157,900.00	5,042,070.00	115,830.00	97.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	-	-
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-	-	-
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	823,310,700.00	803,023,784.07	20,286,915.93	97.54
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	650,853,500.00	645,941,300.00	4,912,200.00	99.25
131001	Улсын төсвөөс санхүүжих	650,853,500.00	645,941,300.00	4,912,200.00	99.25
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	73,693,700.00	71,376,372.95	2,317,327.05	96.86
132001	Орон нутгийн төсвөөс	73,693,700.00	71,376,372.95	2,317,327.05	96.86
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	98,763,500.00	85,706,111.12	13,057,388.88	86.78
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	87,000.00	157,000.00	(70,000.00)	180.46
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	98,676,500.00	85,549,111.12	13,127,388.88	86.70
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	118,132,633.17	(118,132,633.17)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	32,583,522.05	(32,583,522.05)	

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 170,707.8 мянган төгрөгийн 2 алдаа -г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

3.1 Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Үндсэн хөрөнгийн тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,800.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар авснаар тайлагнасан байна.
- Шилэн дансанд таван саяас дээш 163,554.0 мянган төгрөгийн орлогын 10 гүйлгээ мэдээлээгүй, 5,353.8 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээ мэдээлээгүйг нөхөн байршуулсан.

Залруулагдаагүй 8,927.7 мянган төгрөгийн 2 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар 8,927.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2 зөвлөмж хүргүүллээ.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн өдөрт 5.0 мянган төгрөгөөр тооцон цалингийн зардлаас 17,995.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид унаа хоолны хөнгөлөлтийг төсвийн төсөлд тусган, баталсан төсвийн хүрээнд зарцуулах.

Хоёр. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Батлагдсан төсөвт тусгагдаагүй архив, бичиг хэргийн албан тушаалын ажил хавсруулж, 8,927.7 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, тогтоомжийг хүрээнд албан хаагчдад ажил хавсран гүйцэтгэх цалингийн зардлыг төсөвт тусгуулан, батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын Хүүхдийн цэцэрлэг	Үндсэн хөрөнгийн тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,800.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар авснаар тайлагнасан байна.	1	1,800.0	-	-	1	1,800.0	1	1,800.0	-	-	-	-
	Шилэн дансанд таван саяас дээш 163,554.0 мянган төгрөгийн орлогын 10 гүйлгээ мэдээлээгүй, 5,353.8 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээ мэдээлээгүй байна.	1	168,907.8	1	168,907.8			1	168,907.8				
Дүн		2	170,707.8	1	168,907.8	1	1,800.0	2	170,707.8	-	-	-	-

Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын Хүүхдийн цэцэрлэг	Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн тушаалаар өдөрт 5.0 мянган төгрөгөөр тооцон цалингийн зардлаас 17,995.0 мянган төгрөгийг олгосон байна.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-
	Батлагдсан төсөвт тусгагдаагүй архив, бичиг хэргийн албан тушаалын ажил хавсруулж, 8,927.7 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон байна.	1	8,927.7	-	-	-	-	-	1	8,927.7	-	-
Дүн		2	8,927.7	-	-	-	-	2	8,927.7	-	-	

Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			